



Үүсгэн байгуулагчийн сургаал

Төлөв даруу байснаар хүмүүст хүндлэгддэг

Шагжамүни бурхан өөрийн шавь болон эгэл жирийн сүсэгтэн ямар ч зүйл асуусан “Сайн болой. Сайн болой. Маш зөв асуулт асуулаа.” хэмээн магтаж, ярилцаж буй хүнээ ухааран ойлготол нь нэг бүрчлэн нухацтайгаар асуултад нь хариулдаг байсан. “Тиймхэн юм мэдэхгүй гэж үү.” гэсэн царай огтхон ч гаргадаггүй тул түүнтэй уулзаж, дуу хоолойг нь сонсох төдийд сэтгэл зүрх цэлмэдэг.

Ажиглаад байхад нийгэмлэгт үүрэг хүлээж аваад, гайхамшигтайгаар дэвжин дээшлэх нэгэн байхад эсрэгээрээ байх хүн ч байдаг. Тэдний ялгаа гэвэл би зааж өгч байна гэсэн сэтгэлтэй байх уу эсвэл бусдынхаа зааж зааварласны

ачаар чадаж байна гэсэн сэтгэлтэй байх уу гэдэгт хамаг учир байх шиг. Хүмүүс хэлсэн бүгдийг нь зөвшөөрөн “За.”, “За.” хэмээн сонсоод байхаар нэг л мэдэхэд биеэ тоон, муу зуршил нь харагдах үе байдаг.

Сургаал номын үүрэг бол хүний бурханлаг чанарыг хүндлэн мөргөх үйл юм. “Хэд хэлбэл ойлгох юм бол” гэсэн сэтгэл төрж байвал биеэ тоож эхэлж байгаагийн шинж.

Сүсэгтэн олны ачаар л бурханы нигүүлсэхүй гэж юу болохыг ухааран ойлгож байна гэсэн сэтгэлтэй байх чухал. Энэ нь төлөв даруу сэтгэл юм шүү дээ.

«Үүсгэн байгуулагчийн үг» Х186-187

Living the Lotus Vol. 177 (2020.06)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Сайтоо Коичироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Залхуу хойрго сэтгэлдээ ялагдахгүй байх

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Номын мөрд хичээхийн чухлыг мэдэх

Эртний нэгэн алдартай дуунд “Болохгүй гэдгийг нь мэдсэн ч больж эс чадна.” гэсэн бадаг бий. Сонин содон илэрхийлэл нь бидний сэтгэл зүрхийг маш тодорхой харуулсан байдаг.

Ер нь бид юм л бол хийх ёстой зүйлээ хийхгүй хойрголож, хийхгүй хэмээн шийдсэн зүйлээ нэг л мэдэхэд хийчихсэн байдаг. Тэгээд дараа нь “Мэдсээр байж...” хэмээн харамсах үе цөөнгүй байдаг болов уу.

Бурханы шашинд “Машид номын мөрд хичээх”-ийн чухлыг сургасан байдаг. Мөн түүнчлэн Күнз зэрэг цэцэн мэргэдийн сургаалд ч машид хичээн суралцаж, төлөв даруу байхад хичээхийн чухлыг сурган айлдсан байдаг. Учир нь хүний оюун санааны хөгжилд “Ингээд болно.” гэсэн хязгаар байдаггүй шүү дээ.

Бурханы зам мөрийг “Үүнээс өөр оройн дээд зам үгүй.” гэсэн утгаар “Дээргүй зам мөр” гэж ярьдаг. Харин би энэ үгийн утгыг “Хичнээн гэгээрсэн ч гэсэн тэр бол энэ замын төгсгөл биш. Билиг оюуныг олж авах боломжид хязгаар үгүй.” хэмээн хүлээж авах юм бол өөдөө тэмүүлсэн эрч хүч ундрэн гарч ирнэ гэж боддог юм.

Тиймээс л үргэлжид номын мөрд хичээх нь маш чухал зүйл байтал бид нэг л мэдэхэд “Жаахан таслахад гайгүй биз” гэсэн ахархан бодолдоо дийлэгдчихдэг.

“Самуун сэтгэл хийгээд цалгар назгай бодлоо гэж, бүхий л зовлонгоос ангижран, Нигүүлсэнгүй сэтгэлээр сургаалыг айлдсугай.” хэмээх Цагаан Лянхуа Судрын “Амар амгалан явахуйг өгүүлэх бүлэг”-ийн нэгэн бадаг бий. Хүн болгонд байдаг тэрхүү хойш суух, залхах сэтгэлийг Шагжамүни бурхан ч маш сайн ойлгож байжээ. Тийм ч учраас “Сэтгэлээс гарж ирээд байдаг олон янзын эргэлзээ, төөрөгдлөө хаяж, амар амгалан сэтгэл хийгээд өөрийн хүслээр, баяр хөөртэйгөөр номын мөрд хичээн шамдахын төлөө зүтгээрэй.” хэмээн уг бүлэгт айлдсан гэж бодож байна.





Таныг хүлээн суугаа хүн бий

“Суралцах тусам улам сонирхолтой болж, сэтгэл догдолдог.” гэсэн Күнзийн сургаал бий. Хүүхэд том хүнийг хараад “Тийм болох юмсан.” гэж бодон, дахин давтан даган дуурайдаг шиг, зорилго тавин дахин давтан суралцах үед өөрийн эрхгүй сэтгэл сэргэн баясдаг гэсэн утгатай.

Сүсэг бишрэл ч адилхан. Жишээлбэл “Инээмсэглэхийг хичээе.” “Талархахаа мартахгүй байя.” гэх мэт ямар нэгэн зорилго тавьсан бол түүнийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийн төлөө дахин давтан хийх (машид зам мөрд шамдах)-д л болох юм. Тэр нь “зуршил” болсноор улам бүр баяр хөөрийг мэдрэх болно.

Ингээд бодоод үзэх юм бол яагаад шашин шүтэж байгаа, юуны төлөө өдөр бүр зам мөрд шамдаж байгаа зорилгоо тодорхойлох нь аз жаргалтайгаар номын мөрд хичээн шамдах үндэс болох юм.

Гэвч хүн л болсон хойно үүнийг мэдсээр байж сэтгэл доторх эргэлзээ, тээнэгэлзлэлдээ ялагдчихаад байдаг. Гэхдээ эргэлзэн төөрөлдөх нь ч, амар хялбарыг хүсэх сэтгэл нь ч хүний угийн араншин тул хааяа ч гэсэн өөрийгөө амраах хэрэгтэй гэж бодож байна. Тэр үедээ зорилт болон зорилгоо мартахгүй байхад л болно.

Жишээлбэл судар уншлага, санга нарын уулзалтын тухайд ч гэсэн тогтсон зүйл юм чинь гээд хүсээгүй зүйлээ албадан хийх нь сайн юм биш. Бие таагүй байх, завгүй байсан зэргээс болоод ядарсан бол амарч болно. Номын мөрийг тууштай хэрэгжүүлэхэд албадахыг хориглоно гэсэн үг.

“Амар амгалан явахуйг өгүүлэх бүлэг”-т “Хамаг амьтныг энэрэн нигүүлсэх үед цалгар назгай сэтгэл үл төрнө.” гэсэн байдаг. Бусдын төлөө гэсэн сэтгэлтэй байвал залхаж, залхуурах сэтгэл төрөхгүй гэсэн утгатай. Яаж ч ядарч байсан үр хүүхдийнхээ төлөө үргэлж хөдөлмөрлөх эцэг эхийн хичээл зүтгэлтэй адилхан. Өөрөөр хэлбэл “Намайг хүлээж суугаа хүн байгаа.” гээд бодохоор хүн амин хувиа бодсон үзлээсээ ангижирч, тэр хүнд тус дэм болох юмсан гэсэн хүсэл оргилон гарч ирж, номын мөрийг хэрэгжүүлэх алхам бүр баяр хөөр, аз жаргал болон хувирдаг гэсэн үг билээ.

Япон төдийгүй дэлхий нийтээрээ янз бүрийн асуудал дунд оршиж байна. Та бүхний эргэн тойронд ч гэсэн таныг хүлээн суугаа хүн байгаа болов уу. “Нигүүлсэхүйн сэтгэлээр сургаалыг түгээгээрэй.” гэсэнчлэн хамаг амьтны төлөө тийнхүү сэтгэлээр сургаал айлдахыг хүсч байна.

«Косей» 2020 оны 6 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

«Оройн Дээд Цагаан Лянхуа Судар» Түүнчлэн Ирсэний Насны Чинээг өгүүлэх 16 дугаар бүлэг (эхний хагас)

Бодит үүд хэсгийн гол тулгуур болох “Уран аргасыг өгүүлэх бүлгийн хоёр дугаар хэсэг”-т “Юмсын жинхэнэ дүр төрх”-ийн тухай айлдсан. Дүгнэлт нь “Эхээс төгсгөл хүртэлх бүх юмс ижил тэгш” буюу “Нүдэнд харагдах юмс үзэгдэл нь тогтсон нэг хууль дүрмийн дагуу янз бүрээр өөрчлөгдөх ч, эхнээсээ (Үндэс) дуустал (сүүл, төгсгөл) бүгд адил.” гэсэн байдаг. Тэр бол ердөө л философийн ухааны жинхэнэ үнэн бөгөөд туйлын хүйтэн хөндий зүйл юм. Тийм учир тэрхүү жинхэнэ үнэнийг ухаарч гэгээрлээ гээд шууд хүнийг аврах, утга учиртай амьдралыг бий болгоход ашиглах боломжгүй.

Тиймээс ч Шагжамүни бурхан тэрхүү жинхэнэ үнэнийг хүнд зориулж, “Хүний үндсэн мөн чанар бол бурханлаг чанар юм.” гэсэн хандлага руу чиглүүлж, алгуураар айлдсаар байсан. Анхнаасаа түүнийг тодорхой айлдлаа гээд олон хүнд шууд ойлгуулах нь бэрх тул жишээ яриагаар сургах, өнгөрсөн ертөнцийн үлгэрээр илэрхийлэх, далд утгаар улам улам хүмүүсийн зүрх сэтгэлийг тэр чиглэлд хандуулсаар иржээ.

Ялж төгс нөгчсөний тунхаглал

Эцэст нь энэхүү “Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх 16 дугаар бүлэг” –ийн сургаалаар тэрхүү жинхэнэ үнэнийг тодорхой айлддаг байна. Өөрөөр хэлбэл бурханы амь нас үхэшгүй мөнх бөгөөд тэрхүү бурханыг Ялж төгс нөгчсөн жинхэнэ бурхан хэмээгээд, зөвхөн Шагжамүни бурханыг л Ялж төгс нөгчсөн жинхэнэ бурхан гэж айлджээ. Мөн хүн бол (хүнээс гадна бүх амьтад) тэрхүү Ялж Төгс нөгчсөн бурханы ач ивээлээр амьдарч буй бурханы жинхэнэ хүүхэд гэдгийг тодорхой болгож өгсөн. Ингэснээр хүйтэн хөндий философын шинжтэй байсан “Хамаг юмсын жинхэнэ дүр төрх” сургаал хүний сэтгэл зүрхэнд хүрсэнээр хүмүүс “Би чинь Ялж төгс нөгчсөн Язгуурын Буддагийн хайр нигүүлсэлд багтаж, түүний ачаар амьдарч яваа юм байна шүү дээ,” гэсэн гүн гүнзгий талархах сэтгэлтэй болдог. Тэгж байж л жинхэнэ аз жаргалыг бий болгож, жинхэнэ утга учиртай амьдралын амт мэдрэгдэх болно.

Бодит үүд хэсэгт философийн шинжтэй сургаал гардаг бол үндсэн үүд хэсэг нь түүнийг

амь оруулах энергийг өгдөг шашны сургаалын хамгийн төгс хэлбэр юм. Тиймээс уг бүлгийг Цагаан Лянхуа Судар төдийгүй бүх судрын амин сүнс нь гэсэн учиртай.

Энэхүү бүлэгт тийм жинхэнэ үнэнийг онолын талаас нь ч гэсэн айлдсан ба ямар ч агуулгатай байсан бүх хүнд ойлгомжтой байх үүднээс сэтгэлээ зориулан айлдсан “Сайн отчийн үлгэр” -ийг гол цөм нь гэж хэлж болно. Тиймээс тэрхүү жишээнд үндэслэн сургаалын гол агуулгыг бодож үзэцгээе.



Сайн отчийн үлгэр

Нэгэн газарт нэг сайн оточ байжээ. Гайхмаар мундаг эрдэм мэдлэгтэй, эмийн жор бичихдээ ч гаргуун, ямар ч өвчнийг анагаах чадвартай оточ юм гэнэ.

Тэр маш олон хүүхэдтэй ба ажлаар өөр орон руу явсан хойгуур нь хүүхдүүд нь андуураад хортой эм уучихжээ. Оточ аав нь хэрвээ гэртээ байсан бол тийм зүйл болохгүй байх байсан ба эзгүй хойгуур нь дур зоргоороо аашилснаас болж тийм зүйл болдог.



Хор үйлчлэх тусам хүүхдүүд нь газраар нэг эвхэрч унаж зовж байв. Аз болж тэр үед аав нь гэртээ харьж ирдэг. Хүүхдүүдийн заримд нь хор бараг үйлчлээгүй, зарим нь хорноос болж ухаан санаа балартсан байсан ч гэртээ харьж ирсэн аавыгаа хараад бүгд адил маш их баярлажээ.

Бүгд аавынхаа өмнө өвдөг сөгдөн, “Ааваа, ямар азаар та харьж ирэв ээ. Бид тэнэг зүйл хийчихлээ. Андуураад хор уучихсан. Эмчилж өгөөч. Амь авраач.” хэмээн гуйна.

Аав нь зовж байгаа хүүхдүүдээ хараад, сайн үйлчилгээтэй эмчилгээний өвсийг өнгө, амт, үнэрийн аль сайныг нь сонгон, уухад амар болгоод хүүхдүүдээ өгчээ. “Энэ бол гайхалтай нөлөөлдөг эм. За, шууд уу. Одоогийн өвчин зовиур чинь эдгэмэгц дахиж өвчин тусахгүй байх болно.”

Ухаан санаа эрүүл байсан хүүхдүүд шууд тэр эмнээс уусан тул хорноос болж өвдөж зовиурлаж байсан нь ор мөргүй алга болжээ. Харин гүн хордсон хүүхдүүд нь саяхан л “Өвчнийг минь эдгээж өгөөч.” гэж гуйж байсан атал хэрэг болгон хийж өгсөн эмийг нь ууя ч гэхгүй байлаа. Учир нь хорноос болж ухаан санаа нь балартсан тул тэр эмний өнгө нь муухай, мөн хачин үнэртэй юм шиг санагдаад, уумаар санагдахгүй байжээ.

Тэр байдлыг харсан аав нь ингэж бодов. “Ай, харамсалтай яа. Хорноос болоод сэтгэл нь бүр самуурчихаж. Яах ч аргагүй юм даа. Ийм болсноос хойш өөр арга хэрэглэж, энэ хүүхдүүдийн эмийг заавал уулгах арга бодъё.”

Тэгээд аав нь “Хүүхдүүдээ, сайн сонсож бай. Би хэдийн нас өндөр болж, үхэх хугацаа минь ойртож байна. Гэтэл дахин хийх ажил гарч, өөр улс руу явах шаардлагатай боллоо. Тиймээс энэ сайн эмийг энд тавиад орхих тул заавал авч уугаарай.” хэмээн захиж үлдээгээд яваад өгчээ. Замынхаа дундаас элч илгээж “Аав тань нас нөгчсөн.” гэж хэл дуулгуулдаг.

Түүнийг сонссон хүүхдүүд нь маш их цочирдож, харуусчээ. “Үгүй ээ, аав минь байсан ч болоосой.” хэмээн сэтгэлээр унаж, сэтгэл нь өвдөв. Тэрхүү цочролоосоо болоод ухаан санаа нь эргээд эрүүл болов.

Тэгээд анх удаагаа аавынхаа үлдээсэн эмний өнгө, үнэр ямар сайхан болохыг анзаарч, тэр дор нь уутал шууд л өвчин зовиур нь ор мөргүй арилжээ.

Хүүхдүүд эдгэнгүүт дөнгөж саяхан өөд болсон гэж байсан аав нь эрүүл саруул эргэн ирдэг байна.



Хор болох эм гэдэг бол таван хүслийн шунал, гэм ба сайн эм гэдэг нь бурхан багшийн сургаал юм.

Эгэл хүмүүс янз бүрийн хүсэл шуналтай байх ба түүний үүсэн бий болох хамгийн том шалтгааныг хайж үзвэл “Нүдэндээ харагдаж байгааг л бодитой зүйл хэмээн бодож, түүндээ автагдсанаар шунахай сэтгэлийг бий болгодог.” гэсэн энэ үгэнд буй. Өөрийн биеэс эхлээд нүдэндээ харагдсан янз бүрийн эд зүйл, мөнгө төгрөг, эргэн тойрондоо болж буй үйл явдлыг бат бөх оршин буй зүйл хэмээн хардагаас болж тэдгээрт автан, төөрөлдөн зовж байдаг.

Шүтэн барилдлагаар харах

Тэгээд Шагжамүни бурхан “Энэ хорвоогийн бүх юмс үзэгдэл шалтгаан ба нөхцлөөс бий болдог түрхэн зуурын илрэлээс үл хэтрэнэ. Тэрхүү шалтгаан ба нөхцөл үгүй бол юмс үзэгдэл ч байхгүй бөгөөд өөр шалтгаан ба нөхцөлтэй учирах юм бол түүнд таарсан үзэгдэл бий болдог хэмээн жинхэнэ үнэнийг (Шүтэн барилдлагын сургаал) сургасан. Тэрхүү жинхэнэ үнэний тухай “Арван хоёр шүтэн барилдлага”, “Хутагтын дөрвөн үнэн”, “Хутагтын найман мөр”, “Зургаан барамид” зэрэг янз бүрийн сургаал айлдсан байдаг. Эдгээр сургаалаар олон хүнийг төөрөгдлөөс ангижуурлж, амар амгалан сэтгэлийн хязгаарт хүргэж чадсан.

Шунал хүсэл, нүглийн уг үндэс юу вэ

Алдарт оточ аав бол Бурхан багш бөгөөд хүүхдүүд нь эгэл жирийн хүмүүс бид билээ.

Залхуу хойрго сэтгэлдээ ялагдахгүй байх

Та бүхэн сайн байцгаана уу?

Шинэ төрлийн корона вирусын халдвар ингэж дэлхийн хэмжээнд тархах юм гэж санасангүй шүү.

Юунд ч гуйвахгүй итгэл үнэмшилтэй байвал сэтгэл амар амгалан байж чадна гэж сураад байгаа мөртлөө л, цаг хугацаа өнгөрөх тусам залхуу хойрго сэтгэл гарч ирж, бүгдээрээ баримтална гэж шийдсэн зүйлээ хүртэл хэрэгжүүлэхгүй, жоохон хойш суухад яавал гэж хэмээн боддог.

Ерөнхийлөгч энэ сарын сургаалдаа “Залхуу хойрго сэтгэлдээ ялагдахгүй байх”-ын тулд зорилготой байх болон хэн нэгний төлөө үргэлж бодож байх чухал хэмээн айлдсан.


Үүсгэн байгуулагч “Бүх хүмүүсийн аз жаргал, дэлхийн энх тайвны төлөө” гэсэн зорилгоор энэ нийгэмлэгийг байгуулсан. Бид тэрхүү агуу хүсэл мөрөөдлийг өөрсдийнхөө зорилго гэдгийг ухамсрлаж, түүний төлөө өдөр бүрийг үр бүтээлтэй өнгөрөөх хэрэгтэй гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи





Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
POBox 33636, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona
Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org
URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento
Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437
Email: info@rkina.org URL: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA
TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745
Email: dharmasanantonio@gmail.com
URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261
Email: rkseattlewashington@gmail.com
URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar, New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo, Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunagar, P.S.: Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district, Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>